

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|-----|--|---|
| 01. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2 |
| 02. | Захиргааны хариуцлагын тухай
хуульд нэмэлт оруулах тухай | 4 |
| 03. | Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай | 4 |
| 04. | Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 5 |
| 05. | Улсын тэмдэгтийн хураамжийн тухай
хуульд нэмэлт оруулах тухай | 6 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|--|-----------|---|
| 06. | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд
нэмэлт оруулах тухай болон Эрүүл мэндийн
тухай хуульд нэмэлт оруулах тухай
хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 78 | 6 |
| 07. | Тамхины хяналтын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл буцаах тухай | Дугаар 80 | 7 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|-----|--|------------|---|
| 08. | Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн
албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 154 | 7 |
|-----|--|------------|---|

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- | | | | |
|-----|---|-----------|---|
| 09. | Хуульчийн эрх зүйн байдлын тухай
хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь
хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг
зөрчсөн эсэх тухай маргааныг хянан
шийдвэрлэсэн тухай | Дугаар 08 | 8 |
|-----|---|-----------|---|



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 12 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/34 дүгээр зүйлийн 34.1.6 дахь заалт:

“34.1.6.эд хөрөнгийн үнэлгээ тогтоолгох;”

2/40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэг:

“40.4.Шийдвэр гүйцэтгэгч нь эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламжийн болон харилцах дансны мэдээллийг авах саналыг шийдвэр гүйцэтгэх албаны даргад гаргах бөгөөд шийдвэр гүйцэтгэх албаны дарга уг саналын үндэслэлийг хянана.”

3/133 дугаар зүйлийн 133.4.4 дэх заалт:

“133.4.4.шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх.”

2 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “мөнгийг шилжүүлэх,” гэсний дараа “оршин суугаа /оршин байгаа/ газрын хаягийг өөрчилсөн бол шийдвэр гүйцэтгэгчид гурав хоногийн дотор мэдэгдэх,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/34 дүгээр зүйлийн 34.3, 34.4 дэх хэсэг:

“34.3.Төлбөр авагч, төлбөр төлөгч нь шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, түүний гаргасан шийдвэрийг зөвшөөрөхгүй бол ажиллагаа явагдсан өдрөөс, уг ажиллагаа хэзээ, хаана явагдсаныг мэдээгүй бол өөрт мэдэгдсэн өдрөөс хойш гомдлоо долоо хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргана. Ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэж тогтоол гаргах бөгөөд энэ тогтоолыг эс зөвшөөрвөл долоо



хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно. Гомдлыг шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр нь эцсийн шийдвэр байна.

34.4.Энэ хуулийн 34.3 дахь хэсэг нь гуравдагч этгээдийн эрх хөндөгдсөн асуудлаарх гомдлыг шүүхээр хянан шийдвэрлэхэд хамаарахгүй.”

2/40 дүгээр зүйлийн 40.1-40.3 дахь хэсэг:

“40.1.Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсний дараа төлбөр авагчийн хүсэлтийг үндэслэн төлбөр төлөгчөөс доор дурдсан эд хөрөнгийн тухай мэдүүлгийг авна:

40.1.1.төлбөр төлөгчийн өмчлөлийн эд хөрөнгө, банкин дахь мөнгөн хөрөнгийн тухай;

40.1.2.төлбөр төлөгчийн өмчлөлийн хөрөнгө бусдын эзэмшилд байгаа, эсхүл ирээдүйд бий болох бусад эд хөрөнгийн тухай.

40.2.Төлбөр төлөгч нь эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах талаар мэдэгдсэнээс хойш долоо хоногийн дотор үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй. Төлбөр авагч ирээгүй нь уг мэдүүлгийг авахад саад болохгүй.

40.3.Хөрөнгийн байдалд орсон аливаа өөрчлөлтийн талаар төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэж, өөрчлөлтийг мэдүүлнэ.”

3/143 дугаар зүйлийн 143.1 дэх хэсэг:

“143.1.Энэ хуулийн 34.1-д зааснаас бусад шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны үйл ажиллагаатай холбоотой гомдлыг холбогдох этгээд уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор дээд шатны албан тушаалтанд гаргана.”

4 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.6 дахь заалтын дугаарыг “34.1.7” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-40.6 дахь хэсэг, 51 дүгээр зүйл, 87 дугаар зүйлийн 87.3, 87.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 12 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30⁴ дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хүч хэрэглэсэн” гэсний дараа “, эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс татгалзсан, зайлсхийсэн, уг мэдүүлгийг тогтоосон хугацаанд өгөөгүй, худал мэдүүлсэн” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 12 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.2.7 дахь заалт нэмсүгэй:

“7.2.7.эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн төлбөр төлөгчийн дансны мэдээлэл авахаар шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан хүсэлтийг шийдвэр гүйцэтгэх албаны дарга зөвшөөрсөн.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 12 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хуулийн 177 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 177.5 дахь хэсэг нэмсүгэй:

“177.5.Дуудлага худалдаатай холбогдсон зардлыг үүрэг гүйцэтгэгч хариуцна.”

2 дугаар зүйл.Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/177 дугаар зүйлийн 177.1 дэх хэсэг:

“177.1.Дуудлага худалдаагаар худалдах үл хөдлөх эд хөрөнгийн санал болгох доод үнийг дуудлага худалдаа явуулахаас өмнө үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч, өмчлөгч харилцан тохиролцож тогтоосон үнийн, хэрэв тохиролцоогүй бол үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 70 хувиар тооцон тогтооно. Үнэлгээчнийг дуудлага худалдаа явуулах эрх бүхий этгээд томилно.”

2/177 дугаар зүйлийн 177.4 дэх хэсэг:

“177.4.Хоёр дахь дуудлага худалдааны доод үнийг харилцан тохиролцож тогтоосон, эсхүл үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 50 хувиар тооцон тогтооно.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.4 дэх заалт нэмсүгэй:

“7.1.4. шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой шүүхэд гаргах гомдолд энэ хуулийн 7.1.2-т заасан хэмжээгээр.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 78

Улаанбаатар
хот

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт оруулах тухай болон Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн 2014 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт оруулах тухай болон Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 80

Улаанбаатар
хот

**Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт
оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн 2014 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2014 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 154

Улаанбаатар
хот

**Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн
албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2-т заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн тул Сандагийн Нямжавыг Улсын дээд шүүхийн шүүгч, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний, Дагвадоржийн Тунгалаг, Алтангэрэлийн Доржготов, Пүрэвийн Цэцгээ нарыг Улсын дээд шүүхийн шүүгчийн, Тэрбишийн Энхтуяаг Иргэний хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Намхайн Цогоог Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Самбуугийн Чулуунааг Сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Бадарчийн Бямбахорлоог Сум дундын 21 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас 2015 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**2014 оны 12 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот**Хуульчийн эрх зүйн байдлын тухай
хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг
Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх
тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 13:00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Амарсанаа даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Т.Лхагваа, Д.Сугар/илтгэгч/, Д.Наранчимэг, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч Монгол Улсын иргэн С.Номынбаясгалан, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар оролцлоо.

Хуралдаанаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэсэн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Иргэн С.Номынбаясгалан 2014 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээлэл гаргажээ:

“Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлд эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд “өмгөөлөгч”, “прокурор”-ын мэргэжлийн үйл ажиллагааны чиг үүрэг, бүрэн эрхийг адилтган авч үзсэн нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч төрийн тусгай албан хаагч болох прокурорын суурь зарчмуудыг зөрчиж, улмаар Үндсэн хуулиар бие даасан эрх зүйн үйл ажиллагаа явуулдаг өөр өөр институт байхад Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа гэх малгай ойлголтын дор хамтатган зохицуулж прокурор, өмгөөлөгчийн үйл ажиллагааг нэг мэт үнэлсэн нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг илэрхийлж байна.



Үндсэн хуулиар прокурор нь нийтийн эрх, ашиг сонирхлыг төлөөлж байгаагийнхаа хувьд аливаа шүүх хуралдаанд буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “Төр, түүний байгууллага”-ыг төлөөлөн оролцохоор зохицуулснаас биш, “Үйлчлүүлэгч буюу хувь этгээд”-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, өмгөөлөх эрхийг олгоогүй билээ.

Эрх зүйн хэм хэмжээний утга санаа, агуулгыг тодорхой болгохын тулд үгийн болон өгүүлбэрийн бүтцийн холбоосонд дүн шинжилгээ хийж, түүнд үндэслэн тайлбарладаг хэл зүйн аргаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг тайлбарлавал:

Хуульч нь шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох гэсэн үйл ажиллагааг явуулахад нэгдүгээрт, өмгөөлөгч шүүхэд төлөөлөх эрхээ нээлгэсэн байх; хоёрдугаарт, прокурор шүүхэд төлөөлөх эрхээ нээлгэсэн байх гэсэн хоёр утга санааг илэрхийлж байна. Гэхдээ шүүхэд төлөөлөх эрхээ нээлгэсэн прокурорын мэргэжлийн үйл ажиллагаанд энэ нь хамааралтай эсэх нь эргэлзээтэй төдийгүй “үйлчлүүлэгч” гэх үг нь “төр” гэх утга санааг илэрхийлэх эсэх нь тодорхойгүй байна. Үндсэн хуулиар прокурорт эрх хэмжээг олгохдоо: нэгдүгээрт, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих; хоёрдугаарт, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох, мөн төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний болон захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоор хуульчилж, түүний эрх хэмжээг тодорхой хүрээнд байхаар хязгаарлан тогтоосон юм.

Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт “Хуульч нь энэ хуулийн 24.1.5-д заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа энэ хуулийн 30, 31 дүгээр зүйлд заасны дагуу шүүхэд төлөөлөх эрхээ нээлгэсэн байна.” гэж хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэсэн заалтыг зөрчсөн байх тул хянан хэлэлцэж дүгнэлт гаргаж өгнө үү” гэжээ.

Хоёр. Иргэн С.Номынбаясгалангийн мэдээлэлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн үзэл баримтлалаар 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн заалт хууль зүйн үйлчилгээ үзүүлэх, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхэд түлхүү хамаарч байна.



Харин прокурор нь төрийн тусгай албан хаагч бөгөөд түүний мэргэжлийн үйл ажиллагаа бусдыг “яллахад оршино” гэсэн мэдээлэл гаргагчийн үзэл санаатай миний бие нэг байна.

Учир нь Прокурорын байгууллагын тухай хуулиар хуульчийн шалгалтад ороод тэнцэн, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг нь баталгаажуулсан албан ёсны баримт бичиг авсан бөгөөд хуульчийн мэргэжлээр 3-аас доошгүй жил ажилласан иргэнийг тангараг өргүүлж, прокурорын албан тушаалд томилно.

Ийнхүү төрийн албан хаагч болох прокурор нь дээр дурдсан тангараг өргөснөөр төрийг төлөөлж, төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох эрх хэмжээтэй болж байгааг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох зохицуулалт бататган бэхжүүлсэн эрх зүйн харилцаа юм.

Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.” гэсэн байна.

Гурав. Улсын Ерөнхий Прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх Г.Эрдэнэбат Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“...Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн.” гэж Прокурорын байгууллагын тухай хуульд заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэж заасан чиг үүргийг прокурорын байгууллага хэрэгжүүлж байна.

Мэдээлэлд “... хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан өмгөөлөгч, прокурор, шүүгчийг нэгтгэн, тухайлсан хуульчийн тухай ойлголтоос ерөнхийлсөн хуульч гэсэн ойлголтоор авч үзсэн байна. Хуульч, түүний мэргэжлийн үйл ажиллагаануудыг төсөөтэй мэт үзэж, тэдгээрийн зааг ялгааг гаргаагүй байна. ...” гэсэн нь үндэслэлтэй байна.

Гэвч энэ нь хуульд өөрчлөлт оруулж, хуулийг боловсронгуй болгохтой холбоотой хууль тогтоогчийн гүйцэтгэх үүрэг бөгөөд прокурорт

олгосон эрх, үүрэг, прокурорын үйл ажиллагааны үндсэн зарчмыг гажуудуулж, Үндсэн хуулийг зөрчсөн зөрчил биш гэж үзэж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өгсөн тайлбараас үзэхэд хууль тогтоогч нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалтад заасан “үйлчлүүлэгч” гэснийг өргөн утгаар буюу төрийг хамааруулан хуульчилсан байх тул Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24.2 дахь хэсэгт “Хуульч нь энэ хуулийн 24.1.5-д заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа энэ хуулийн 30, 31 дүгээр зүйлд заасны дагуу шүүхэд төлөөлөх эрхээ нээлгэсэн байна.” гэсэн нь Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор ... шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэснийг зөрчиж байна гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны төрөл” гэсэн 24 дүгээр зүйлд өмгөөлөгчийн үйл ажиллагааны чиглэлийг голчлон дурдсан атлаа хуульч /шүүгч, прокурор, өмгөөлөгч/-д нийтлэг хамаарахаар томъёолсон нь уг хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байгааг харуулж байна.

3.Хуульч /өмгөөлөгч/-ийн шүүхэд төлөөлөх эрх нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлд Улсын дээд шүүхэд бүртгүүлснээр, харин хуульч /прокурор/-ийн шүүхэд төлөөлөх эрх нь мөн хуулийн 31 дүгээр зүйлд тангараг өргөснөөр үүсэхээр тусгайлан заасан байна.

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2003 онд хянан шийдвэрлээд гаргасан 02 дугаар тогтоол нь прокурорын тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхийн зөрчлийн талаар гаргасан шийдвэр болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон



**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС
ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “Хуульч нь энэ хуулийн 24.1.5-д заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа энэ хуулийн 30, 31 дүгээр зүйлд заасны дагуу шүүхэд төлөөлөх эрхээ нээлгэсэн байна.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.” гэснийг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Ж.АМАРСАНАА

ГИШҮҮД

Т.ЛХАГВАА

Д.СУГАР

Д.НАРАНЧИМЭГ

Д.ГАНЗОРИГ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

Индекс: 14003